

ТЗСХ-ын 2021 ОНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГ 2015 ОНЫ ДҮНТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	2015	2021	ӨӨРЧЛӨЛТ	ТАЙЛБАР
1. Анхны батлагдсан төсөвтэй харьцуулсан нийт зарлагын гүйцэтгэл	D	B	+	Сүүлийн 3 жилийн хугацаанд зарлагын бодит гүйцэтгэл нь төсөвлөсөн зарлагаас 10%-аас бага хувийн зөрүүтэй гарсан.
2. Анхны батлагдсан төсөвтэй харьцуулсан зарлагын бүрдлийн гүйцэтгэл	C+	A	+	Зарлагын бүрдлийн зөрүү нь сүүлийн 3 жил тутамд 5%-аас бага байсан.
3. Анхны батлагдсан төсөвтэй харьцуулсан нийт орлогын гүйцэтгэл	D	C	+	Дотоодын бодит орлого сүүлийн 3 жилийн хоёрт нь төсөвлөсөн орлогын 92%-116%-ийн хооронд, зөвхөн нэг жилд нь 112% -аас илүү байсан.
4. Хугацаа хэтэрсэн өрийн зардал, хяналт	C	A	+	Хугацаа хэтэрсэн өрийн хэмжээ сүүлийн гурван жилийн хугацаанд зарлагын 2%-аас хэтрээгүй бол өмнөх үнэлгээний явцад энэ нь 3.9% байсан байна.
5. Төсвийн ангилал	C	C	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
6. Төсвийн баримт бичигт багтсан мэдээллийн иж бүрэн байдал	A	B	-	Өргөн барьсан төсвийн баримт бичигт есөн элементээс 2015 онд долоо, 2021 онд зургаан элемент орсон тул үнэлгээ буурсан. МУ-ын 2021 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад макро эдийн засгийн ирээдүйн чиг хандлагын тооцоог тусгасан хэдий ч хүү болон валютын ханшны төсөөллийг тодорхойлон тусгаагүй.
7. Тайлангаас гадуурх засгийн газрын үйл ажиллагаа	D+	C+	+	Өмнөх үнэлгээний үед төсвөөс гадуурх зарлага УТ-ийн нийт зарлагын 28%-ийг эзэлж байсан бол одоо бүх зардлыг төсөвлөж, Засгийн газрын жилийн санхүүгийн тайланд тусгаж байна.
8. Төсвийн шатлал хоорондын харилцааны ил тод байдал	A	A	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
9. Улсын салбарын бусад байгууллагуудын төсөвт үзүүлж буй нийт эрсдэлд хяналт тавих байдал	C+	C+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
10. Төсвийн гол мэдээллийн олон нийтэд хүртээмжтэй байдал	A	A	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
11. Жилийн төсвийн процессын дэс дараалал ба оролцоо	A	A	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
12. Төсвийн төлөвлөлт, зарлагын бодлого, төсөв боловсруулалтын олон жилийн хэтийн төлөв	C	C	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
13. Татвар төлөгчийн үүрэг, хариуцлагын ил тод байдал	C+	A	+	Татварын гол хууль тогтоомж, журам нь ойлгомжтой бөгөөд иж бүрэн, оролцогч төрийн байгууллагуудын эрх үүрэг тодорхой болсон.
14. Татвар төлөгчийн бүртгэл, татварын төлөвлөгөөний үр дүнтэй байдал	C+	B+	+	Татвар төлөгчийн бүртгэлийн системийг Татварын багц хуулийн дагуу амжилттай хэрэгжүүлж байгаа тул оноо сайжирсан.
15. Татварын төлбөр цуглуулалт үр дүнтэй эсэх	C+	B+	+	Жилийн татвар хураалт 75%-аас дээш үзүүлэлттэй байна.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	2015	2021	ӨӨРЧЛӨЛТ	ТАЙЛБАР
16. Зарлагын амлалтыг хангах мөнгөн хөрөнгийн хэрэгцээний урьдчилан таамаглал	D+	C+	+	Мөнгөн хөрөнгийн төсөөллийг төсвийн жилээр боловсруулан мөнгөн гүйлгээний гүйцэтгэлд үндэслэн долоо хоног бүр шинэчилж байна.
17. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өр, баталгааг бүртгэх, удирдах	C	B	+	Өрийн мэдээллийг ТС-гийн мэдээтэй сар бүр тооцоо нийлдэгээс гадна нийт өрийн баталгааны дээд хязгаарт багтаан зөвхөн эрх бүхий байгууллагаар батлуулсны үндсэн дээр ЗГ гэрээ байгуулдагаас шалтгаалан оноо сайжирсан.
18. Цалин хөлсний хяналтын үр дүнтэй байдал	D+	B+	+	Төрийн албаны цалингийн нэгдсэн системийг хөгжүүлж, нийт төсвийн байгууллагын 97%-ийг хамруулсан.
19. Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөөнт нээлттэй байдал, гомдол шийдвэрлэх механизм	D+	D+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
20. Цалингийн бус зардлын дотоод хяналтын үр дүнтэй байдал	D+	D+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
21. Дотоод аудитын үр дүнтэй байдал	C+	C+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
22. Дансны нэгтгэлийг цаг тухайд нь, тогтмол хийж буй байдал	B+	B+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
23. Төрийн үйлчилгээний нэгжийн хүлээн авсан хөрөнгө нөөцийн талаарх мэдээлэл бий эсэх	A	C	-	Шилэн дансны портал дээр үйлчилгээ үзүүлэгч нэгжийн санхүүгийн тайланг нийтэлдэг боловч мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, тайлагнадаггүй.
24. Жилийн явцын төсвийн мэдээ, тайлангийн чанар, цаг тухайд нь хүргэдэг байдал	C+	C+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
25. Жилийн санхүүгийн тайлангийн чанар, цаг тухайд нь хүргэдэг байдал	C+	D+	-	ЗГСНТ-д нэгтгэгдэж байгаа ТС, НДС зэрэг байгууллагуудын татварын орлого, НДШ-ийн өр төлбөр зэргийг олон улсын стандартын дагуу бүрэн аккрузал сууриар бүртгэх тогтолцоо бүрдээгүй тул “тохируулсан” аккрузал сууриар хөтлөн бэлтгэж байна.
26. Хөндлөнгийн аудитын хамрах хүрээ, мөн чанар, хяналт	B+	A	+	Аудитын тайланг ҮАГ санхүүгийн тайланг хүлээн авснаас хойш 8 сарын дотор хууль тогтоогчдод өргөн мэдүүлдэг байсан бол сүүлийн гурван жилийн байдлаар хугацаа 3 сар болж буурсан.
27. Жилийн төсвийн тухай хууль тогтоомжийн хяналт	B+	B+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.
28. Хөндлөнгийн аудитын тайлангийн хууль тогтоомжийн хяналт	D+	D+	↔	Оноонд өөрчлөлт ороогүй.